

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ

/2015 оны 9-р сарын 30-наас 2015 оны 10-р сарын 28-ны байдлаар, төгрөгөөр/

№	Барааны нэр, төрөл	IX/30	X/07	X/14	X/21	X/28
1	Гурил, I зэрэг, кг	1200	1200	1200	1200	1200
2	Хонины мах, кг/ ястай/	6000	5500	5500	5250	5000
3	Үхрийн мах, кг /ястай/	7500	6500	6500	6000	6000
4	Ямааны мах /ястай /	5500	4500	4500	4500	4500
5	Элсэн чихэр, кг	1500	1500	1500	1500	1500
6	Цагаан будаа, кг	2300	2300	2300	2300	2300
7	Шингэн сүү, л	1200	1200	1200	1200	1300
8	Ямааны ноолуурын үнэ 1 кг- цагаан	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
9	- Бор ноолуур	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй	зарагдаагүй
10	Бензин, А-80, 1 литр	1570	1570	1570	1570	1570
11	Бензин, А-92, 1 литр	1690	1690	1690	1690	1690
12	Дизелийн түлш, 1 литр	1790	1790	1790	1790	1790

Гол нэрийн барааны үнийн 7 хоногийн мэдээгээр аймгийн төвд 2015 оны 9-р сарын 30-наас 2015 оны 10-р сарын 28-ны хооронд хонь, үхэр, ямааны ястай мах, шингэн сүүнээс бусад бүтээгдэхүүний үнэ тогтвортой байв. Ямааны ноолуурын арилжаа хийгээгүй байна.

Махны үнэ. 9-р сарын 30-нд хонины 1 кг ястай мах 6000 төгрөгийн ханштай байсан бол 10-р сарын 7-нд өмнөх 7 хоногийн мөн үеэс 8.3 хувиар, 10-р сарын 28-нд мөн өмнөх 7 хоногийн мөн үеэс 4.8 хувиар тус тус буурч 5000 төгрөг болов. Үхрийн ястай мах 9-р сарын 30-нд 7500 төгрөгийн ханштай байсан бол 10-р сарын 7-нд өмнөх долоо хоногийн мөн үеэс 13.3 хувиар, 10-р сарын 21-нд өмнөх долоо хоногийн мөн үеэс 7.7 хувиар тус тус буурч 6000 төгрөгийн ханштай болж 14 хоногийн турш хадгалагдаж байна. Ямааны ястай махны үнэ энэ хугацаанд 5500-4500 төгрөг болон буурч сүүлийн 4 долоо хоног ханш тогтвортой байв.

Гурил, элсэн чихэр, цагаан будаа. Алтан тариа ХК-ын 1-р гурил, элсэн чихэр, цагаан будааны үнэ сүүлийн 5 долоо хоногийн турш тогтвортой байлаа.

Шингэн сүү. 9-р сарын 30-наас 10-р сарын 21-ийг хүртэл 1 литр сүү 1200 төгрөгийн ханштай байсан ба 10-р сарын 28-нд өмнөх долоо хоногийн мөн үеэс 8.3 хувиар өсч 1300 төгрөг болов.

Шатахууны үнэ. Шатахууны ханш тайлант хугацаанд хэвээр байна.

